

Улаанбаатар


ХОТЫН ОРШИН СУУГЧИЙН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот

2022 он

ХОТЫН СОЁЛ

Улаанбаатар хотын оршин суугчийн авлага



Улаанбаатар

ХОТЫН ОРШИН СУУГЧИЙН ГАРЫН АВЛАГА

I. Баримт бичгийн тухай

1. Зорилго **01**
2. Хамрах хүрээ **01**
3. Норматив эшлэл **01**

II. Нийслэл Улаанбаатар хотын тухай


1. Үүссэн түүхэн замнал **01**
2. Цаг агаарын онцлог тал **01**
3. Нийслэлийн өөрийн онцлог тэмдэглэн өнгөрүүлдэг баярын талаарх мэдээлэл **01**

III. Хотын оршин суугч

1. Хотын түр болон байнгын оршин суугчийн талаарх мэдээллийг багтаасан байх **01**
2. Хотод шилжилт хөдөлгөөнийг хэрхэн хийдэг талаар /хөдөөд орон нутгаас болон дүүрэг хооронд шилжих хөдөлгөөнийг хэрхэн хийдэг талаарх мэдээллийг агуулсан байх/ **01**
3. Оршин суугч нь амьдарч буй орчиндоо хэрхэн өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах талаар тусгасан байна. **01**
4. Хог хаягдлын талаарх мэдээллийг энэ хэсэгт оруулах /дахиврыг хаана авдаг, хэрхэн ялгах талаарх мэдээлэл орсон байх/ **01**

IV. Нийслэл хот дахь боловсролын байгууллага

1. Бага дунд сургуульд хэрхэн хамрагдан сурах тухай **01**
2. Нийслэлд байрлах их дээд сургууль, тэдгээрийн оюутны хотхоны талаарх мэдээллийг оруулах **01**
3. Нийтийн номын сан **01**



V. Соёл урлаг, спортын байгууламжууд

1. Нийтийг хамарсан үзвэр үйлчилгээний газруудын мэдээллийг багтаасан байх /музей, театр/ **01**
2. Спорт цогцолборын талаарх мэдээлэлд нийслэлд байгаа Богд уул болон Чингэлтэй хайрханд алхалт хийх маршрутын талаарх болон чөлөөлт цагаа өнгөрөөх боломжтой газруудын мэдээллийг оруулах **01**

VI. Харилцаа холбоо

1. Шуудан **01**
2. Утас **01**
3. Интернет **01**

VII. Тээвэр


1. Нийтийн тээвэр **01**
2. Такси дуудлага **01**
3. Хувийн тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцох **01**
4. Галт тэрэг **01**
5. Нисэх онгоц **01**

VIII. Үйлчилгээ

1. Эрүүл мэндийн үйлчилгээ **01**
2. Хоолны үйлчилгээ **01**
3. Худалдааны төвүүдийн мэдээлэл **01**
4. Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээ **01**

IX. Аюулгүй байдлаа хангах санамж мэдээлэл

1. Яаралтай тусламжийн төвүүдийн мэдээлэл **01**
2. Хуулийн зөвлөн туслах үйлчилгээний талаарх мэдээлэл **01**





УЛААНБААТАР ХОТЫН ОРШИН СУУГЧИЙН ГАРЫН АВЛАГА

ЗОРИЛГО

Энэхүү баримт бичиг нь хотын оршин суугчид амьдралын хэвийн үйл ажиллагаагаа явуулахад оролцох эрх үүргийн боломжит нийтлэг харилцааг зохицуулах талаар мэдээлэл, арга зүйн удирдамж, зан үйл, хийж хэвшүүлбэл зохих дадал, хотын соёлыг төлөвшүүлэх талаар зөвлөмжийг иж бүрнээр товч ойлгомжтой байдлаар тодорхойлоход оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү баримт бичиг нь Нийслэл хотод байнга болон түр оршин суугч, хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд, гадаадын жуулчдад зориулагдав.

НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Хотын оршин суугч – гэж Нийслэлийн засаг захиргааны нэгжид бүртгүүлэн хууль ёсоор байнга болон түр оршин суугч гадаад дотоодын иргэдийг нийслэл хотын оршин суугчийг;

Орон сууц – гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэрийг;

Төрийн үйлчилгээ – гэж олон нийтийн хэрэгцээг хангах зорилго бүхий төрийн байгууллагууд эсвэл төрийн хяналт, зохицуулалтаар явуулдаг бүхий л үйл ажиллагааг;

01 БАРИМТ БИЧГИЙН ТУХАЙ

- Зорилго
- Хамрах хүрээ
- Норматив эшлэл





<https://www.facebook.com/groups/206196306823942> (Гэрэл зурагт дурлагсдын фэйсбүүк групп)

<https://www.facebook.com/drakula.lord>

02 НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫНТУХАЙ

- Үүссэн түүхэн замнал
- Нийслэлийн тэмдэглэлт өдрүүд
- Цаг агаарын онцлог





УЛААНБААТАР ХОТЫН ТҮҮХЭН ЗАМНАЛ

Улаанбаатар хот нь 1912 онд Монгол Улсын нийслэл болон улмаар Монгол Улсын нийслэл хот болох эрх зүйн үндэс нь анх 1924 оны Үндсэн хуулиар бий болсон.

1940, 1960 оны Үндсэн хуульд тусгагдсан нь нүүдлийн соёл иргэншилтэй манай улсын хувьд суурин соёл иргэншилд шилжих чухал шийдвэр болж, дэлхийн хот байгуулалт, төлөвлөлтийн жишгээр Улаанбаатар хотыг төлөвлөн хөгжүүлэх шаардлага бий болсон.

Монгол улсын нийслэл бол монголчуудын эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл, тусгаар тогтносон орны улс төр, эдийн засаг, шашин, соёлын төвийн түүх, монголчуудын бэлгэдэл юм.

Улаанбаатар хотын түүхэн замналыг товч үзүүлбэл:



Өргөө нь өнөөгийн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын үүсэл юм.

1


Өргөө
1636-1651



Өргөө нэрээр анх ханаа дугуйлсан нийслэл хотын анхны нэр Номын хүрээ болон өөрчлөгдсөн.

2

Номын хүрээ
/1651-1706/



Энэ үеийн онцлог нь Их хүрээ суурьшиж хот болон хөгжиж эхэлсэн. Их хүрээ 1706-1911 онд одоогийн Улаанбаатар хотын төв хэсэг болох Сэлбийн голын хөндийд суурьшсан.

3

Их хүрээ
/1706-1911/



Сэргээн байгуулагдсан Монгол улсын нийслэл болсон үе. Нийслэл хүрээ нь улс орны амьдралд онцгой үүрэг гүйцэтгэх болсон.

4

Нийслэл хүрээ
/1912-1921/



1924 онд нийслэл хотыг улсын нийслэл хот гэдгийг давтан хуульчилж хотын нэрийг Улаанбаатар хот хэмээн өөрчилсөн.

5


Улаанбаатар хот
/1924 оноос одоо хүртэл/



НИЙСЛЭЛИЙН СҮЛД ТЭМДЭГ ХАНГАРДИ

1994 онд батлагдсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд нийслэл хот сүлд, туг, тэмдэгтэй байх бөгөөд загварыг нь НИТХ-аас тогтооно гэсний дагуу уралдаанд шалгарсан Р.Лхамсүрэн зураачийн эх загвар хангарди сүлд албан ёсоор нийслэл Улаанбаатар хотын сүлд болж батлагджээ.

Хангарди сүлдний бэлгэдлийг дараах байдлаар тайлбарласан байдаг.



Нийслэлийн сүлд тэмдэг нь мөрөвчид дугуй дүрсний төвд байрласан Богдхан уулын уламжлалт шүтээн Хангарди байна. Хангарди нь бат түвшин эрэмгий байдлыг илэрхийлж нийслэл хот өргөжиж алдар нэр нь тив дэлхийд мандан бадрахын утга санааг агуулна.



УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

Ангилал	Агуулга
Газар нутаг, байршил	- Газар нутаг: 4,705 км ² - Байршил: Хатан Туул голын хөвөөнд, Хан Богд уулын хормойд Монгол улсын төвийн бүсэд, далайн түвшнээс 1350 м-т оршдог.
Хүн ам	1,539,810 (2019)
Дүүрэг	Сүхбаатар, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул, Багануур, Налайх, Багахангай
Хороо	173
Хүн амын нягтшил (1 км ² -т ногдох хүн)	327.6
Цагийн бүс	UTC +8
Олон нийтийн арга хэмжээ	- Дээлтэй монгол 7 дугаар сарын 10 - Улаанбаатар өвлийн наадам 2 дугаар сард - Олон улсын марафон гүйлтийн уралдаан 6 дугаар сард - Үндэсний наадам 7 дугаар сарын 11-ээс 15



03 ХОТЫН ОРШИН СУУГЧ

- Хотын түр болон байнгын оршин суугч
- Хотод шилжилт хөдөлгөөнийг хэрхэн хийх
- Оршин суугч нь амьдарч буй орчиндоо хэрхэн өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах
- Хог хаягдал /дахиврыг хаана авдаг, хэрхэн ялгах/





ХОТЫН ТҮР БОЛОН БАЙНГЫН ОРШИН СУУГЧЫН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, ИРГЭНИЙ БҮРТГЭЛ

Улаанбаатар хотод шилжин суурьшихдаа шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийлгэх шаардлагатай. Шилжин суурьшихдаа шаардлагатай баримт бичгийг бүрдүүлж, оршин суух газрынхаа /сум, хорооны/ улсын бүртгэгчид 10 хоногийн дотор өөрийн биеэр бүртгүүлнэ.

Шилжилт хөдөлгөөнийг бүртгүүлэхэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

- Иргэний үнэмлэх;
- 16 нас хүрээгүй хүүхэдтэй иргэн оршин суух бол хүүхдийн төрсний гэрчилгээ;
- Оршин суух газрын хаягийг нотлох баримт бичиг.

Оршин суух газрын хаягаа нотлох баримт бичиг гэдэгт:

- Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
- Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ;
- Нотариатаар гэрчлүүлсэн түрээсийн, захиалгын зэрэг гэрээ;
- Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх, эсхүл эзэмшигчийн бичгээр гаргасан оршин суулгах тухай зөвшөөрөл.

Баримт бичгийг улсын байцаагч хүлээж авснаас хойш ажлын 3 өдрийн дотор шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хөтөлнө.





НИЙТИЙН БОЛОН АМИНЫ СУУЦНЫ ОРШИН СУУГЧ АНХААРАХ ЗҮЙЛС

Нийтийн болон орон сууцанд оршин суугч та дараах шаардлагыг биелүүлнэ. Үүнд:

- Нийтийн ашиглалтын талбайг /орц, дотор талбай, гадна тохижилт гэх мэт/ ариг гамтай ашиглаж өөриймсөг хандах;
- Соёлч бус, зөрчил гаргаж буй иргэнд шаардлага тавьдаг байх;
- Хогоо зориулалтын хогийн цэгт хаяж хэвших;
- Дүүрэг, хороо, СӨХ-өөс хэрэгжүүлж буй оршин суугчдыг хамарсан бүхий л нийтийн үйл ажиллагааг дэмжин идэвхтэй оролцох;
- Оршин суугчид хөрш болон бусад оршин суугчдад хүндэтгэлтэй хандах;
- Орон сууцандаа засвар хийх бол бусдын амар, тайван байдлыг алдагдуулалгүй зөвшөөрөгдсөн цагийн дагуу засвараа хийх,
- Орон сууцны засварын ажил урт хугацаагаар хийгдэх бол бусад оршин суугчдад урьдчилан мэдэгдэх;
- Тэжээвэр амьтныг салхилуулахдаа олон нийтийн газар бие зассан тохиолдолд бохирыг цэвэрлэх бөгөөд хошуувч, хүзүүний таних тэмдэг зүүлгэж хэвших;
- Орон сууцны жижүүр, харуулын үйл ажиллагаанд хяналт тавих /орчны цэвэрлэгээ, аюулгүй байдлын тэмдэглэл г.м/;
- Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж байгуулах, арчилгааг тогтмол хийхэд өөрийн оролцоог бий болгох;
- Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийг сүйтгэх, зориулалтын бусаар ашигласан иргэнд шаардлага тавих;
- Оршин суугчдын дундах цахим орчин дахь бүлэг /групп/-ийн хэрэглээг зүй зохистой ашиглах /бусдын цахим орон зайг хүндэтгэн үзэх/;

Амины сууцанд оршин суугч та дараах шаардлагыг биелүүлнэ. Үүнд:

- Амины сууцанд суугч иргэн та эдэлбэр газар дээрх барилга, байгууламжийн төлөвлөлтийг зөв хийх;
- Амины сууц, эдэлбэр газарт эрүүл ахуйн шаардлагыг ханган ил задгай хог хаягдал хаяхгүй байх;
- Хог хаягдлыг ангилах сав байршуулан, ангиллын дагуу хаях;
- Эдэлбэр газартаа үнсийг хаях галын аюулгүй байдлыг хангасан савыг бусад хог хаягдлын савнаас тусад нь байгуулах;

- Угаарын хийнд хордохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх /яндангаа ойр ойрхон хөөлөх, зууханд онгорхой, цууралт байгаа эсэхийг тогтмол шалгаж байх/;
- Галлагаанд зөвхөн сайжруулсан шахмал түлш хэрэглэх;
- Угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг орон байрандаа тогтмол зааврын дагуу ашиглаж хэвших;
- Ашиглах, заавар зөвлөмжийн дагуу угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг хянаж эвдрэл гэмтэл үүсэхээс сэргийлэх;
- Ариун цэврийн байгууламж /нүхэн жорлон, угаадасны нүх/-г хөрс бохирдуулахаас сэргийлэн MNS 5924:2015 стандартын дагуу байгуулан ашиглах;
- Эдэлбэр газартаа цэцэрлэгжүүлэлт, хүлэмж, ногоон байгууламжийг байгуулан арчилгааг тогтмол хийх;



Нийтийн болон амины сууцанд оршин суугчдын анхаарах зүйлс

Орон байрны аюулгүй байдлыг хангах

Оршин суугч та орон байрны болон хувийн аюулгүй байдлыг хангахдаа дараах зүйлсийг шалгаж хэвшээрэй.

1. Цонх, тагтаа хааж түгжсэн эсэх;
2. Цахилгаан хэрэгслүүдийг залгуурт залгаатай байгаа эсэхийг бүрэн шалгасан эсэх;
3. Хий /газ/ ашигладаг бол хаасан эсэхээ шалгах;
4. Ариун цэврийн өрөө, гал тогооны өрөө гэх мэт өрөөнүүдийн усыг бүрэн хаасан эсэх;
5. Өрөөнүүдийн гэрэл, чийдэнг унтраасан эсэх;
6. Галын, угаарын хий мэдрэгч зэрэг төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг шалгасан эсэх;
7. Хэрэв дохиоллын систем, камертай бол хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгах.
 - Оршин суугч та эрчим хүч, цахилгаантай холбоотой мэдээллийг 7004-7004
 - Орон сууцны халаалт, хэрэглээний халуун хүйтэн усны доголдол ариутгах татуурга, төлбөрийн мэдээлэл, үйлчилгээтэй холбоотой мэдээлэл, гомдол, лавлагааг 7000-5454, 70111761 авах боломжтой



ХОГ ХАЯГДАЛ

Хог хаягдлыг ангилан ялгах, тээвэрлэх зааварчилгаа:

Иргэн та хог хаягдлаа эх үүсвэр дээр нь зөв ангилан ялгаж хэвшээрэй. Доорх зурагт хог ангилан ялгах зааварчилгааг харуулав.

ХОГ АНГИЛАХ ЗААВАРЧИЛГАА

Анхаарах: • Өнгө • Төрөл • Тээвэр хийх өдөр

ЛХАГВА	БААСАН	БЯМБА	ХУВААРЬТ ӨДӨР	ХУВААРЬТ ӨДӨР
ШИЛ, ЛААЗ	ХУВАНЦАР	ЦААС	ХҮНС	БУСАД
 Архи, пиво, дарсан ногооны шил Бүх төрлийн шилэн сав, Лаазалсан бүтээгдэхүүний сав Ундааны лааз	 Ундаа, усны сав Гялгар уут, Гоо сайхан, Ахуйн хэрэглээний бүх төрлийн хуванцар	 Бор картон цаас	 Хоолны үлдэгдэл Жимс, ногооны хальс Өндөг, өндөгний хальс Кофе, цайны шаар Гурилан бүтээгдэхүүн Модон шүдний чичлүүр Цаасан салгетка	 Дахин боловсруулах боломжгүй хаягдлууд

Хогны уутыг хаанаас авах вэ?

15-20 литрийн багтаамжтай хогны 4 өнгийн уутыг байрны ойролцоох дэлгүүрт үйлдвэрийн үнээр худалдаалдаг.

Дахивар хог хаягдлыг дахин боловсруулах

Иргэн та дахин боловсруулах боломжтой хог хаягдлаа “UB 3R open data” буюу газарзүйн мэдээллийн системийн платформыг ашиглан дахивар худалдан авах цэгүүдийн байршил болон Дахивар хүлээн авах машины байршлыг харснаар өөрт ойр байрлах байршлыг сонгон үйлчлүүлэх боломжтой.

Дахин боловсруулах боломжтой дахивар хаягдал



Шил, лааз, хуванцар сав, гялгар уут гээд дахин боловсруулах боломжтой дахивар хог хаягдлаа ангилан ялгаж Улаанбаатар хотод үйл ажмлагаагаа явуулж буй дахивар худалдан авах цэгүүдэд борлуулах боломжтой.

Дахивар худалдан авах цэгүүдийн байршил болон мэдээллийг UB 3R open data платформоос харах боломжтой.

ЭКОКЭШ буюу Дахивар хүлээн авах машин



-Хуванцар, лааз, цаасан хайрцаг зэрэг дахивар буюу дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг тус машинд тушаагаад төлбөрөө QR код уншуулах эсвэл тасалбараар авна.

-QR кодоо Mongol Chat-ийн дурангаар уншуулмагц таны виртуал дансанд шимтгэлгүйгээр мөнгө шууд орно.

-Салбаруудын байршлыг UB 3R open data платформуос харах боломжтой.

-Хуванцар сав тус бүрийн үнэ: 20 ₮

/Эх сурвалж: Ulaanbaatar 3r open data/

Хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах

Иргэн та хоол хүнсний хаягдал үлдэгдлээ дахин боловсруулснаар хөдөө аж ахуйд бордоо, тэжээл болгон ашиглах боломжтой. Мөн цэцэрлэг, ногооны талбай, таримал зүлэг болон цэцгийн мандлаа бордох боломжтой.



Мөн хүнсний хаягдлыг дахин боловсруулж, бордоо хийх технологийг илүү өргөн цар хүрээнд нэвтрүүлж иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл” хэрэгжиж байна. Төслийн талаар дэлэрэнгүй мэдээллийг <http://www.ubservice.mn/> сайтаас авах боломжтой.

/Эх сурвалж: Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба/



<https://www.facebook.com/groups/206196306823942> (Гэрэл зурагт дурлагсдын фэйсбүүк групп)

<https://www.facebook.com/ArguNPhotography>

04 НИЙСЛЭЛ ХОТ ДАХЬ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА

- Бага дунд сургуульд хэрхэн хамрагдах
- Нийслэлд байрлах их дээд сургууль, түүнд хэрхэн хамрагдах





БОЛОВСРОЛ

Монгол Улсад боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролоос бүрддэг.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

Монгол улс сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн асуудлыг цогцоор нь авч үздэг бөгөөд сургуулийн өмнөх хүүхдийн нас нь 2аас 5настай танин мэдэхүй, нийгэмшил болон бие бялдрын хөгжлийн хувьд чухал ач холбогдолтой нас гэж үздэг.

Сургуулийн өмнөх боловсрол нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх ба “Хүүхдийн цэцэрлэг” гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллага юм.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь улсын болон хувийн цэцэрлэг, цэцэрлэг – бага сургуулийн цогцолбор хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг. Цэцэрлэг нь тусгай цэцэрлэг, сувиллын цэцэрлэг, асрамжийн цэцэрлэг, халамжийн цэцэрлэг гэсэн хэв шинжтэй байна. Сургуулийн өмнөх боловсролд хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны бүх хүүхдийг хамруулдаг.

Цэцэрлэгийн бүртгэл, элсэлтийн үйл ажиллагааны цахим бүртгэл тухайн онд зарлагдах бөгөөд зарлагдсан хугацаанд та хүүхдээ бүртгүүлнэ.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ

Монгол улс Боловсролын тухай хуулиар суурь боловсролыг (1-9-р анги төгстөл) иргэн бүрд үнэ төлбөргүй, заавал эзэмшүүлэхээр хуультай байдаг. Элсэлтийн насыг 6 нас сургалтын хугацааг 12 жилтэй.

12 жилийн сургалтад бага анги (6-10 нас), дунд анги (11-14 нас) болон ахлах анги (15-17 нас)) хамрагдана. Бага, дунд боловсрол нь иргэнд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх ба бага боловсролыг 5, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилд тус тус эзэмшүүлнэ.

Монгол улсын хэмжээнд Улсын бүртгэлийн ерөнхий газраас тухайн хичээлийн жилд нэгдүгээр ангид элсэх хүүхдүүдийн мэдээллээр цахим сан үүсгэсэн бөгөөд эцэг, эх, асран хамгаалагчид /Parent.esis.edu.mn/ системд өөрийн мэйл хаягаараа нэвтэрч, хамран сургах тойргийнхоо сургуульдаа элсэх хүсэлт илгээж бүртгүүлнэ.

Ерөнхий боловсролын сургуульд хамрагдахад:

Монгол улсын хэмжээнд Улсын бүртгэлийн ерөнхий газраас тухайн хичээлийн жилд нэгдүгээр ангид элсэх хүүхдүүдийн мэдээллээр цахим сан үүсгэсэн бөгөөд эцэг, эх, асран хамгаалагчид /Parent.esis.edu.mn/ системд өөрийн мэйл хаягаараа нэвтэрч, хамран сургах тойргийнхоо сургуульдаа элсэх хүсэлт илгээж бүртгүүлэх боломжтой.

Элсэлтийн цахим бүртгэлийн үйл ажиллагаа схем:



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Цахимаар бүртгүүлэх болон дэлгэрэнгүй мэдээллийг PARENT.EDU.MN вэб сайтаас авах боломжтой.

ИХ ДЭЭД БОЛОВСРОЛ

Дээд боловсрол гэж талуудын зохих эрх бүхий байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн дээд боловсролын тогтолцоонд хамаарах бүрэн дунд боловсролын дараах шатны боловсрол, сургалт эсвэл судалгааг хэлнэ.

Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино.

Дээд боловсролын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэших хэсгээс бүрдэх бөгөөд эдгээр хэсэг тус бүрийн агуулга нь дараах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ:

Ерөнхий суурь хэсгийн агуулга: нь суралцагчид дээд боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;

Мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь суралцагчид шинжлэх ухаан, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай онол- арга зүйн мэдлэг эзэмшүүлэх;

Мэргэших хэсгийн агуулга нь суралцагчид нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тухайн мэргэжлээр мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх, зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны үр чадвар олгох.

Дээд боловсролын зэрэг нь багц цагаар хэмжигдэх дипломын, бакалаврын, магистрын, докторын шатлалтай байна.

Оюутан элсүүлэх ажлыг дараах үе шаттай зохион байгуулна.

- Шалгуулагч элсэлтийн ерөнхий шалгалт өгнө.
- Элсэлтийн ерөнхий шалгалт нь монгол хэл, математик, нийгмийн тухай мэдлэг, Монгол Улсын түүх, англи хэл, орос хэл, хими, физик, биологи, газарзүйн хичээлийн агуулгад үндэслэн бэлтгэсэн тестийн хэлбэртэй байна. Монгол хэл, бичгийн шалгалтыг элсэлтийн ерөнхий шалгалт өгөх бүх иргэн заавал өгнө.
- Элсэлтийн Ерөнхий шалгалтыг хичээлийн жилд нэг удаа зохион байгуулна. Ерөнхий шалгалт авах хугацааг боловсролын үнэлгээний байгууллага /цаашид “Боловсролын үнэлгээний төв” гэх/ боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн тогтооно.



- Боловсролын үнэлгээний төв элсэлтийн ерөнхий шалгалтыг үндэсний төвшинд зохион байгуулна.
- Элсэлтийн Ерөнхий шалгалтын дүнгийн тухай баримт бичиг түүнийг олгосон өдрөөс хойш 2 жил 6 сарын хугацаанд хүчинтэй байна.
- Ерөнхий шалгалт өгч, зохих болзлыг хангасан иргэдийн өргөдлийг дээд боловсролын сургалтын байгууллага хүлээн авч, өөрийн тогтоосон шалгуурыг бүрэн хангасан иргэнийг элсүүлнэ. Дээд боловсролын сургалтын байгууллага ерөнхий шалгалтын онооноос гадна харгалзах өөрийн шалгуур (бүрэн дунд боловсролын үнэмлэхийн дүн, багш нарын тодорхойлолт, эссе, авьяас чадварын шалгалт, ярилцлага)-ыг тодорхойлон мөрдөж болно

Дээд боловсролын сургалтын байгууллага нь оюутан элсүүлэх мэргэжил, хяналтын тоо, тухайн мэргэжлээр сурах норматив хугацаа, сургалтын төлбөр, заавал өгөх шалгалт болон шалгалтын оноо, дүнд тавих шаардлага зэрэг сургууль, мэргэжлээ сонгоход шаардлагатай мэдээллийг сургуулийн цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулна.

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ

Мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалт, түүнчлэн мэргэжлийн сургалт олгох үйл ажиллагааг хамтад нь мэргэжлийн боловсрол, сургалт гэнэ.

Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь чиг үүргээсээ хамааран мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын болон мэргэжлийн сургалтын гэсэн ангилалтай байна.

Мэргэжлийн боловсролд:

“Мэргэжлийн боловсрол” гэж тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшилтийг хэлнэ.

“Техникийн боловсрол” гэж техник, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх, удирдах хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн үйлдвэрлэл, техник, технологийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшилтийг хэлнэ.

“Мэргэжлийн сургалт” гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх, давтан сургах, дадлагажуулах, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх, аж ахуй эрхлэх мэдлэг олгох үйл ажиллагааг хэлнэ.

Техникийн боловсролын сургалтын байгууллагад бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой иргэнийг элсүүлнэ.

Ажил, мэргэжлийн тодорхой чадамжийг эзэмших, ур чадвараа дээшлүүлэх, давтан суралцах хүсэлтэй иргэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад нас, боловсролын төвшин харгалзахгүйгээр хөдөлмөр эрхлэх мэргэжлийн болон аж ахуй эрхлэх сургалтад хамрагдана.



<https://www.facebook.com/groups/206196306823942> (Гэрэл зурагт дурлагсдын фэйсбүүк групп)

<https://www.facebook.com/ArguNPhotography>

05 СОЁЛ УРЛАГ, СПОРТЫН БАЙГУУЛАМЖУУД

- Нийтийг хамарсан үзвэр үйлчилгээний газруудын мэдээлэл
- Спорт цогцолборын талаарх мэдээлэл





ХОТЫН 10 ТОМ СОЁЛ УРЛАГ, СПОРТЫН ГАЗАР

Нийслэл Улаанбаатар хотод амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломжтой соёл урлаг, үзвэр үйлчилээ, спортын байгууламж олон байдаг бөгөөд эдгээрээс та сонгон үйлчлүүлэх боломжтой юм.

1. ЧИНГИС ХААН МУЗЕЙ



Аливаа улс орны хөгжлийг тодорхойлох чухал шалгуур бол соёл урлагийн салбар бөгөөд Улаанбаатар хотод Богд хааны музей, Үндэсний хувцасны музей, Монголын үндэсний музей гэх мэт нийт 12 музей, 3 уран зургийн үзэсгэлэн байдаг. Монголын үе үеийн хаадын түүх, түүх дурсгалын үзмэр, орчин үеийн уран зураг сонирходог чөлөөт цагаараа заавал очиж сонирхох газруудын нэг бол Чингис Хаан музей юм.

2. БОГДЫН ХААНЫ ОРДОН МУЗЕЙ

1893- 1903 оны хооронд барьж байгуулан, Монголын шашны тэргүүн VIII Богд хаан таалал төгстөлөө амьдарч, төр, шашны хэргийг захиран, төр улсаа удирдаж байсан дурсгалт газар юм.

ХҮИ-XX зууны эхэн үеийн Монголын хаант төр, шашны түүх, урлаг соёлын давтагдашгүй хосгүй үнэт дурсгалууд, тухайн үед амьдарч асан нэрт урчууд, дархчууд, анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазар, түүний сургуулиар урлаж бүтээсэн цутгамал бурхад, торгон зураг, шороон будаг, цаасан шуумал болон VIII Богд Живзундамба, хатан Дондогдуламын хэрэглэж байсан эдлэл, өмсөж байсан дээл хувцас тэргүүтэн болоод гадаад дотоодын төлөөлөгчдийн өргөл барьц, бэлэг дурсгал, худалдаж авсан эд зүйлсээс дээжлэн олон нийтэд дэлгэн сурталчилж байдаг.



3. ГАНДАНТЭГЧЭНЛИН ХИЙД



Улаанбаатар хотод нийт 226 шашны хийд байдаг. Хэрвээ та шарын шашинтай бол, сүм хийд явах шаардлага гарч байгаа бол Улаанбаатар хотын хамгийн том хийд нь Гандантэгчэнлин хийд юм /монголын бурхан шашны төв ч гэж нэрлэдэг/. Баянгол дүүргийн 16-р хороонд байрладаг.

Та www.gandan.mn цахим хаягаар нэвтрэн ном уншуулах, засал хийлгэх болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой юм.

4. КИНО ТЕАТР

Хотын хэмжээнд нийт 16 кино театр байдаг. Мөн энэ тоо нэмэрдсээр байгаа бөгөөд та кино үзвэрээ тухлан үзэхийн зэрэгцээ гэртээ хамгийн ойр салбарыг сонгон үйлчлүүлэх боломжтой.



5. УЛСЫН ДРАМЫН ЭРДМИЙН ТЕАТР



Нийслэл хотын хэмжээнд нийт 9 театр байдаг. Төв талбайн баруун урд байрлах Драммын театр нь дэргэдээ хүүхэлдэйн театртэй бөгөөд 1931 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр байгуулагдаж, шинэ эрин, шинэ зуун, ардчилал үүсэхийн хэрээр олон улсын болон дотоодын олон жүжиг, дуурь, бүжгийн жүжиг, хүүхэлдэйн жүжиг тавигддаг болсон.

6. ДУУРЬ БҮЖГИЙН ЭРДМИЙН ТЕАТР



1950 оны 12 сарын 30 өдөр тус театрын барилга ашиглалтад орж Б.Дамдинсүрэн, Б.Смирнов нарын хөгжим, Д.Нацагдоржийн цомнол “Учиртай гурван толгой” дууриар хөшгөө нээснээр Монголын хөгжмийн театр үүссэн түүхтэй театр юм.

ДБЭТ-ын урын санд дэлхийн сонгодог болон үндэсний 100 гаруй дуурь балет байдаг бөгөөд өөрийн урын санд байгаа жилдээ 26 дуурь, 21 балетаас сонгон 100 гаруй удаагийн тоглолтыг үзэгчдэдээ хүргэдэг.

7. БУЯНТ УХАА СПОРТ ЦОГЦОЛБОР

Залуусын чөлөөт цагаа өнгөрөөх бас нэг газар бол Буянт Ухаа спорт цогцолбор юм. Байгууллага хамт олноороо тэмцээн уралдаан зохиож үйлчлүүлэх боломжтой бөгөөд голлон заалны спортын арга хэмжээ зохион байгуулагддаг.

2012 онд нээгдэж үйл ажиллагаагаа явуулж буй спортын ордон нь Буянт ухаа нисэх онгоцны буудал явах замд байрладаг. 2829мкв талбайтай, хувцас солих өрөө, волейболын тор, антен, спорт тоглоомын бөмбөг, узел, дифузертэй цогцолбор юм.



8. МӨСӨН ОРДОН- STEPPE ARENA




Хотын хамгийн том иргэн бүрийн заавал очих газрын нэг мөсөн ордон юм. Хан уул дүүргийн Шинэ яармаг хороололын ур талд байрлах ба өвөл зуны аль ч цагт хоккей, уран гулгалт, шорт трейкийн тэмцээн уралдаанаас гадна сагсан бөмбөг, гар бөмбөг, уран сайхны гимнастик, бокс зэрэг багийн болон ганцаарчилсан спортын төрлүүд, соёл, урлагийн тоглолт, экспо, хурал зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах боломжтой.

9. УЛСЫН ТӨВ НОМЫН САН

Нийслэл хотод маань нийт МУИС-ийн 24 цагийн номын сан, Нацагдоржийн нэрэмжит номын сан гэх мэт 9 нийт номын сан байдаг ба анхны нийтийн номын сан нь Төв номын сан юм. Талбайн урд байрладаг бөгөөд олон арван номын цуглуулгатай юм. Сонирхуулахад, зөвхөн Монгол номын фонд одоогоор кирилл бичгийн 150 мянга орчим ном, монгол бичгийн 8000 орчим, Өвөр монгол 4000 орчим ном хадгалагдаж байгаа.



10. SKY RESORT



Улаанбаатар хотын хамгийн их баяр баяслаар дүүрэн газар Sky resort. Хотоос ойр зайд гэр бүл, найз нөхөд, хамт олноороо цэвэр агаарт цана чарга, сноубордаар гулгаж, амтат хоол, халуун ундаа зооглон, өвлийн хамгийн сайхан цаг мөчүүдийг хамтдаа өнгөрөөх боломжтой газар юм.

11. УУЛЫН ЯВГАН АЛХАЛТ

Богд хан ууланд явган аялал хийх Зайсан-Баруун ширээт, Цэцээ гүн, Чингэлтэйн Зүрх уул гэх мэт таван үндсэн маршрут байдаг бөгөөд, эдгээр чиглэлд явган аялагчдад зориулсан сүүдрэвч, сандал, ширээ, хашлага, гүүр, мэдээллийн самбар, Богдхан ууланд амьдардаг ан амьтдын тайлбарыг байршуулсан байдаг. Сүүлийн үед залуус хамт олон, гэр бүлээрээ ууланд алхан чөлөөт цагаа өнгөрөөх болсон.

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.touristinfocenter.mn/> сайтаар орж хүссэн газрынхаа мэдээллийг авах боломжтой.





06 ХАРИЛЦАА ХОЛБОО

- Шуудан
- Утас
- Интернет





УТАС , ХАРИЛЦАА ХОЛБОО, ШУУДАН

Утас, интернэт сүлжээ

Өнөөдрийн байдлаар Монгол улсад харилцаа холбооны үйлчилгээ эрхэлдэг хэд хэдэн оператор компаниуд үйл ажиллагаа явуулдаг.

Гар утасны дугаар авах, интернэт /DATA/ худалдан авах болон бусад үйлчилгээг салбаруудаар биеийн байцаалттай очин үйлчлүүлэн авах боломжтой.

Гадаадаас холбогдохын тулд эхлээд тухайн улсаас олон улсын хандалтын кодыг залган (энэ нь улс бүрд өөр өөр байж болно), дараа нь Монгол улсын код (976), дараа нь холбогдох гэж буй утасны дугаарыг хийн залгана.

Жишээ нь: Олон улсын дугаар +976 12345678 (Утасны дугаар)

Гадаад руу дуудлага хийхдээ ашигладаг үүрэн телефоны операторын код өөр өөр байдаг.

001 - Монголын Цахилгаан холбоо

002 - Скайтел

003 - Мобиком

008 - Юнител

009 – Жи Мобайл



Мэдээлэл харилцаа холбооны техник, технологийн шинэчлэл өдөр тутам өөрчлөгдөн хувьсаж байгаа өнөө үед үүрэн холбооны 2G, 3G технологиос гадна 4 дэх үеийн хөдөлгөөнт холбооны LTE үйлчилгээг ашиглаж байна.

- Та гар утаснаас яаралтай тусламжийн тусгай дугаар руу нэмэлт код оруулалгүй шууд залгах боломжтой;
- Хэрэв төрийн байгууллагын 26 ... дугаараар эхэлсэн утас луу гар утаснаас залгах бол 51 кодыг өмнө оруулж дуудлага хийнэ.

Шуудан, цахилгаан холбоо

Ардын хувьсгал мандсан 1921 оны 07 дугаар сарын 19-нд Ардын засгийн газрын тэргүүлэгчдийн 6 дугаар хурлын тогтоолоор Монгол улсын шуудан бичиг, Цахилгаан мэдээний ерөнхий хороог байгуулсан нь одоогийн “Монгол Шуудан” ХК юм.

Монгол улсын шуудангийн үндсэн сүлжээг эзэмшигч “Монгол Шуудан” ХК нь Монгол Улсын 21 аймаг, дүүргийн 22 Шуудангийн үйлчилгээний газар, 330 сум болон Улаанбаатар хотын 38 Шуудангийн үйлчилгээний салбараар дамжуулан шуудангийн 30 гаруй нэр төрлийн үйлдвэрлэл үйлчилгээг эрхлэн явуулдаг.

Бүтээгдэхүүн үйлчилгээ:

- Дотоод шуудан
- Улс хоорондын шуудан
- Тээвэр зууч
- Хэвлэл захиалга



Утас: 1800-1613

Цахим шуудан: www.mongolpost.mn



UBH
CENTER

TDB

ШУУДАН

<https://www.facebook.com/groups/206196306823942> (Гэрэл зурагт дурлагсдын фэйсбүүк групп)

<https://www.facebook.com/BoldbaatarTsend555555555>

07 ТЭЭВЭР

- Нийтийн тээвэр
- Такси дуудлага
- Хувийн тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцох
- Галт тэрэг
- Нисэх онгоц





НИЙТИЙН ТЭЭВЭР

Нийтийн тээвэр гэж эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтийн үйлчилгээний замын чиглэл, цагийн хуваарийн дагуу болон зохион байгуулалттай гүйцэтгэж байгаа тээвэрлэлт, такси үйлчилгээг тодорхойлно.

АВТОБУС

Нийслэл Улаанбаатар хотод нийтийн тээвэрт хот доторх үйлчилгээний автобус, троллейбус, угсраа автобус гэсэн 3 төрөл байдаг. Нийтийн тээврийн үйлчилгээний цагийн хуваарь өглөө 06.40 минутад эхэлж орой 21.50 минутад зогсоно.

Хот доторх үйлчилгээний автобус	Угсраа автобус	Троллейбус
		
Хотын дотор нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх 2-оос дээш хаалгатай, зорчигчдын суудал цөөн, зогсоогоор явах зорчигчид зориулсан зай илүүтэй, орох, гарах хаалганы орчимд болон эгнээ хоорондын зай өргөн автобус.	Хатуу нугасаар холбогдсон, хоёр буюу түүнээс дээш хэсэг бүхий зорчигч суугаа буюу зогсоогоор зорчин явах, хэсэг хоорондын холбоосоор чөлөөтэй дамжин өнгөрөх, шилжих боломжтой автобус.	Троллейбус нь хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээнд явах автобусны адил тогтоосон шугамын дагуу үйлчилгээ үзүүлэх бөгөөд нэг болон хэд хэдэн цахилгаан хөдөлгүүртэй эрчим хүчний дэд бүтцээс тэжээл авдаг тээврийн хэрэгсэл.

Нийтийн зорчигч тээврээр үйлчлүүлэхдээ иргэн та дараах зүйлсийг анхаарна уу. Үүнд:

- Автобусны хөдөлгөөн бүрэн зогссон үед үйлчлүүлэх /орох, гарах/
- Нийтийн тээврээр зорчихдоо урд хаалгаар орж, арын хаалгаар бууна
- Үйлчилгээний төлбөрийг бэлэн мөнгөөр бус U-money буюу цахим картаар төлөх
- Нийтийн тээврээр зорчихдоо урд хаалгаар орж карт унших төхөөрөмжид картаа уншуулна
- Нэг картаар олон зорчигчийн төлбөр хийхийн тулд эхлээд жолоочид хамт зорчих хүнийхээ тоог хэлж дараа нь картаа уншуулна. (Хөнгөлөлттэй зорчих картын хувьд боломжгүй)
- Тусгай санамж, тэмдэглэгээ бүхий суудалд суухгүй байх
- Буухдаа арын хаалганы карт унших төхөөрөмжид картаа уншуулж бууна.
- Гар утасны “UB Smart Bus” аппликэйшны тусламжтайгаар явах чиглэл, автобус хүлээн хугацааг харах.
- Хувийн аюулгүй байдал, халаасны хулгайгаас сэргийлэн иргэн та цүнхээ урдаа авч байх, бэлэн мөнгө, хэтэвч, гар утас гэх мэт үнэт зүйлсээ дотор, урд халаасандаа хийх.

“U-money” цахим карт

Нийтийн тээврээр зорчихдоо “U-money” /www.u-money.mn/ карт ашиглан төлбөрөө хийх ба картыг ойролцоох автобусны буудлын карт худалдаалах цэгээс шинээр худалдан авах болон цэнэглэнэ.

Гар утасны “Hi-Pay Wallet” аппликэйшны тусламжтайгаар гар утаснаасаа U-money картаа цэнэглэх.

U-money /Ю-монеи/ карт нь энгийн, хүүхдийн, хөнгөлөлттэй гэсэн төрлүүдтэй байдаг.

- Энгийн картыг иргэн бүр ашиглана.
- Хүүхдийн картыг 8-18 нас хүртэлх насны хүүхэд
- Хөнгөлөлттэй зорчих картыг хөгжлийн бэрхшээлтэй иргэн, оюутан, цагдаа, ахмад настан эмэгтэй 55 нас, эрэгтэй 60 наснаас дээш насны иргэдэд тус тус олгодог.



Карт нэг удаад цэнэглэх мөнгөн дүнгийн доод хэмжээ 500 төгрөг, дээд хэмжээ 90,000 төгрөг бөгөөд картын нийт үлдэгдлийн дээд хэмжээ 500,000 байж болно. /2020 он./

- Дамжин суух нөхцөлүүд

- Дамжин суулт хийхдээ эхний тээврийн хэрэгслийн буух төхөөрөмжид картаа заавал уншуулсан байх шаардлагатай.
- Эхний тээврийн хэрэгслийн буух төхөөрөмжид картаа уншуулсан хугацаанаас хойш 30 минутын дотор дамжин суувал хөнгөлөлт эдэлнэ.
- Дамжин суулт хийж буй хоёр дахь тээврийн хэрэгслээс буухдаа картаа заавал уншуулах шаардлагатай.
- Эхний дамжин суултаас хойш 4 цагийн дараагаагийн дамжин суулт хийж хөнгөлөлт эдлэх боломжтой.

- Дамжин суух боломжгүй нөхцөлүүд

- Ижил чиглэлийн тээврийн хэрэгсэлд дахин суувал
- Өмнөх зорчсон тээврийн хэрэгслээс буухдаа картаа уншуулаагүй тохиолдолд
- Дамжин суух хөнгөлөлт эдэлсэн тээврийн хэрэгслээс буух төхөөрөмжид картаа уншуулахгүй буусан тохиолдолд хөнгөлөлт эдэлснээс хойш тэр өдөртөө хөнгөлөлт эдлэх боломжгүй болно.
- Зорчигчийн санал хүсэлт, мэдээллийг 24 цагаар доорх утсаар болон цахим хаягаар хүлээн авдаг.

Цахим хаяг: <http://www.transport.ub.gov.mn>

Цахим шуудан: <http://www.transport.ub.gov.mn>

Утас: 11-326352, 11-323176

Нүүр ном: /Нийтийн тээвэр-Public transport UB/, Нийслэлийн тээврийн газар

- Хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний цагийн хуваарь, замын урт болон үнэ тарифын мэдээллийг дараах цахим хуудас, facebook page, лавлах утаснаас авч болно.

Цахим хаяг: www.transdep.mn/

Цахим шуудан: info@transdep.mn

Утас: 1900-1234

Нүүр ном: www.facebook.com/autoteever/

- “U money карт борлуулах, цэнэглэх цэг” хаяг бүхий автобусны буудлын ойролцоох худалдаа, үйлчилгээний төвүүдэд байрлах цэгүүдэд, гар утасны апплейкешин болон “Улаанбаатар Смарт Карт” ХХК-ийн хэрэглэгчийн төвд хандана.

Цахим хаяг: <http://www.uscc.mn>

Утас: 70151289, 7004 4040-3

ГАЛТ ТЭРЭГ

Галт тэргээр зорчих чиглэлээс хамааран цагийн хуваарь, тасалбарын үнэ өөрчлөгдөнө. Галт тэрэг нь цагийн хуваарийн дагуу явах ба тасалбарыг өөрийн биеэр очиж авах буюу онлайн захиалж болно.

Галт тэргээр зорчихдоо иргэн та дараах зүйлсийг анхаарна уу.

- Зорчих тасалбарыг биеэр болон онлайнгаар захиалах;
- Тасалбар худалдан авах болон зорчихдоо иргэний үнэмлэхтэй байх;
- Зорчигч галт тэрэг хөдлөхөөс 1 цагийн өмнө төмөр замын буудалд ирэх;
- Тасалбарт галт тэрэгний дугаар, суудлын дугаарыг заасан ба тухайн дугаарт заасан галт тэргээр зорчих;
- Галт тэрэг нь 3 төрлийн зэрэглэлтэй /Энгийн, хагас унтлагын, унтлагын г.м/;
- Гар тээшийг хамгийн дээд талд зорчигчдод гэмтэл учруулахгүй байхаар байрлуулах;
- Зөвшөөрөгдсөнөөс илүү гарсан /кг/ ачааг тус чиглэлд явах тээшинд өгч тээвэрлүүлэх;
- Галт тэрэгний тасалбар, зорчихтой холбоотой мэдээллийг авах

Хаяг: Баянгол дүүрэг, Сөүлийн гудамж-42

Цахим хаяг: www.ubtz.mn

Цахим шуудан: ubtz@ubtz.mn

Утас: 21-244420, 1900-1949

Онлайн тасалбар захиалга: www.eticket.ubtz.mn

УБТЗ-ын өртөө

УБТЗ-д ангиггүй-7, 1-р зэргийн-6, 2-р зэргийн-8, 3-р зэргийн-8, 4-р зэргийн-11, 5-р зэргийн-39 нийт 79 өртөө, зөрлөг, УБ дахь ачих буулгах, Замын-Үүд дэх шилжүүлэн ачих анги зэрэг салбар нэгжүүдтэй.



АГААРЫН ТЭЭВЭР

Монгол улсын хэмжээнд авиа компаниуд нь олон улсын болон орон нутгийн чиглэлд нислэгийн үйлчилгээ үзүүлдэг. Дэлхийн 10 гаруй улс орон руу шууд нислэг үйлдэх бөгөөд аялал жуулчлалын улирлаас шалтгаалж тусгай чартер нислэгүүд хийгддэг.

Олон улсын болон орон нутгийн нислэгийг Буянт-Ухаа олон улсын нисэх буудлаас хийдэг. Нисэх онгоцны суудал нь бизнес болон энгийн гэсэн 2 төрөл байдаг.

Онгоцны нислэгээр үйлчлүүлэхдээ иргэн та дараах зүйлсийг анхаарна уу.

- Нислэгийн тасалбараа тасалбар борлуулагчаар дамжуулан захиалах;
- Нислэгийн тасалбараа буцаах, өөрчлөх тохиолдолд холбогдох журмын дагуу өмнө нь мэдэгдэх;
- Нислэгийн цагаас 2 цагийн өмнө нисэх буудалд ирэх ба авто замын түгжрэл, саатлыг тооцож цагаа төлөвлөх;
- Зөвшөөрөгдсөн ачаа тээшнээс илүү гарсан эд зүйлсийг шалгуулан тээшний хэсэгт хадгалуулах;
- Овор хэмжээ ихтэй электрон хэрэгсэл, зөөврийн компьютероо гар тээшнээс нь гаргаж рентген төхөөрөмжөөр шалгуулах;
- Зөвшөөрөгдсөнөөс бусад зүйлсийг авч явахыг хориглох.

Зорчигч нь нислэгийн хуваарийн мэдээллийг 1900-1980 нисэхийн лавлах утсаар 24 цагийн турш мөн www.airport.gov.mn сайтаас нислэгийн хуваарийн мэдээллийг авна.

ТАКСИ

Нийслэлийн хэмжээнд олон такси үйлчилгээний компаниуд, мөн утасны тусгай дуудлагын дугаарууд ажилладаг. Такси үйлчилгээ авахдаа стандарт, аюулгүйн шаардлага хангасан таксины үйлчилгээг сонгох хэрэгтэй.

Такси үйлчилгээ авахдаа иргэн та дараах зүйлсийг анхаарна уу.

- Дуудлагын такси үйлчилгээг гар утасны аппликэйшн ашиглаж үйлчилгээ авах
- Километр хэмжигчийг ажиллаж байгаа эсэхийг хянах
- Зөв боловсон үйлчлүүлэх
- Зорчих үедээ утаат тамхи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх
- Таксинаас буухдаа өөрийн эд зүйлсийг орхигдуулсан эсэхийг шалгах
- Үдэш, орой зорчихдоо өөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс албан ёсны такси үйлчилгээний компанийн таксигаар үйлчлүүлэх.



ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХДОО АНХААРАХ ЗҮЙЛС

Иргэн та замын хөдөлгөөнд тээврийн хэрэгслээр болон явган оролцохдоо дараах зүйлсийг анхаараарай.

- Иргэн та зам хөндлөн гарахдаа зөвхөн явган хүний гарцаар гарч хэвших;
- Авто замын нэгдүгээр эгнээгээр зөвхөн нийтийн тээврийн хэрэгсэл автобус зорчдог тул нэгдүгээр эгнээгээр зорчихгүй байх;
- Хурдны хязгаарыг баримтлах, тээврийн хэрэгслийн хурд нь суурин газарт цагт 60км, суурин газрын гаднах замд цагт 80км, тууш замд 100км байх ба хурдны хязгаарыг хэтрүүлэхийг хориглодог.
- Хороолол, замын зэргэлдээх нутаг дэвсгэр, сургууль орчмын бүс дотор цагт 20 км байна.
- Шаардлагагүй тохиолдолд дуут дохиог ашиглахгүй байх, замын хөдөлгөөнд дүрмийн дагуу, соёлтой оролцох.


ЖОЛООНЫ ҮНЭМЛЭХ

Монгол улсын жолоодох эрхийн үнэмлэх - Тухайн ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт өгч тэнцсэн, 18 нас хүрсэн иргэнд бүрдүүлэх баримт бичгийг үндэслэн олгоно.



Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газар /www.police.gov.mn/

Олон улсын жолоодох эрхийн үнэмлэх - Замын хөдөлгөөний тухай Вений конвенцын гишүүн орноос олгосон, уг конвенцод нийцсэн хүчин төгөлдөр жолоодох эрхийн үнэмлэх бүхий Монгол Улсын иргэнд олгоно.



Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газар /www.police.gov.mn/

Гадаад улсын жолоочийн үнэмлэх солих - Монгол Улсын иргэн болон Монгол Улсад 1 жилээс дээш хугацаагаар оршин суух гадаадын иргэн Замын хөдөлгөөний тухай Вений конвенцын гишүүн орноос олгогдсон, уг конвенцод нийцсэн хүчин төгөлдөр жолоодох эрхийн үнэмлэхээ Монгол Улсын үндэсний жолоочийн үнэмлэхээр солиулах тохиолдолд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

Цахим хаяг: <http://www.license.police.gov.mn>


Цахим шуудан: <http://www.info@police.gov.mn>

Утас: Мэргэжлийн хяналтын хэсэг 70191501, Зөвшөөрөл хяналтын хэсэг 93200100


АВТО ЗОГСООЛ

- Тээврийн хэрэгсэл, авто машиныг зөвхөн авто зогсоолд (төлбөртэй, төлбөргүй) байрлуулах;
- Тээврийн хэрэгслийг авто зам дагуу байрлуулах, эгнээ хааж зогсох, хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно;
- Явган хүний зам дээр авто машиныг гаргаж (унуулж) зогсохгүй байх;
- Авто зогсоолд тээврийн хэрэгслийг байрлуулахдаа холбогдох утасны дугаарын үлдээсэн байх. Дугаар нь ашиглагддаг дугаар байна;
- Гарц, орц, явган хүний зам хааж тээврийн хэрэгслийг байрлуулахгүй байх;
- Зориулалтын бус газар байршуулах, бусдад саад учруулах зэрэг зөрчил үүсгэсэн тохиолдолд 1900-1234 дугаарт холбогдон тус тээврийн хэрэгслийн эзэмшигчтэй холбож өгөх үйлчилгээ авах боломжтой.


Төвлөрсөн ил зогсоолын орох хэсгийн зураглал



Гудамж зам дагуух зогсоол
Зорчих хэсгийн хажуугийн зогсоолын ерөнхий схем



Зогсоолын схем зураг





<https://www.facebook.com/groups/206196306823942> (Гэрэл зурагт дурлагсдын фэйсбүүк групп)

<https://www.facebook.com/ArguNPhotography>

08 ҮЙЛЧИЛГЭЭ

- Төрийн үйлчилгээ
- Эрүүл мэндийн үйлчилгээ
- Хоолны үйлчилгээ
- Худалдааны төвүүдийн мэдээлэл
- Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээ





ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Төрийн үйлчилгээ нь хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн зорилт чиг үүргийг бүтээгдэхүүний хэлбэрээр болон үйлчилгээ үзүүлэх замаар хэрэгжүүлж буй төрийн байгууллагын үйл ажиллагаа юм.

E-MONGOLIA

Төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үзүүлэх, тэдгээр үйлчилгээний нэгдмэл байдлыг бий болгосон, төрийн суурь, системүүдтэй мэдээлэл солилцох боломжтой, инновац, мэдээллийн технологийн шинэлэг, дэвшилтэд шийдэл бүхий төрийн үйлчилгээний суурь систем бол www.e-mongolia.mn юм.

E-SERVICE

Нийслэлийн оршин суугч нь төрийн үйлчилгээний мэдээлэл авах, үйлчилгээний хүсэлтийг цахим хэлбэрээр гаргах, үйлчилгээний санал, гомдол, хүсэлтийг eservice.ulaanbaatar.mn цахим хуудасны өргөдөл, гомдол цэсээр болон 1800-1900 утсаар холбогдон авна. Үйлчилгээг (ажлын өдрүүдэд 09.00–18.00 цагийн хооронд) хүлээн авч шийдвэрлэдэг.

НИЙСЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВ



Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээнүүдийг нэг дор төвлөрүүлж, зарим үйлчилгээний шийдвэрлэх хугацааг богиносгон, иргэдэд учруулж буй чирэгдэл, хүндрэлийг багасгах зорилгоор үйлчилгээ авах таатай нөхцөлийг бүрдүүлж, нийслэлийн нутгийн захиргааны болон төрийн 27 байгууллагын 242 нэр нэр төрлийн үйлчилгээг нэг төвлөрүүлж, харьяалал харгалзахгүй, уртасгасан цагаар ажилладаг байгууллага юм.

Нэгдсэн төвүүдээр үйлчлүүлснээр 200 гаруй төрийн үйлчилгээг нэг дороос авах боломжтой.

- Үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авах
- Банк санхүүгийн лавлагаа
- Ерөнхий боловсролын баримт бичиг нөхөн олгох
- Газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах
- Барилга, байшин, хаяг дугаар бүртгэх
- Татвар төлөгчид тоон гарын үсэг олгох
- Бэлэглэх гэрээг улсын бүртгэлд бүртгэх
- Ажлын байранд зуучлах гэх мэт.

Улаанбаатар хотод Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн 6 салбар үйл ажиллагаа явуулна. Үүнд:

- **Дүнжингарав салбар** - Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, “Дүнжингарав” худалдаа, үйлчилгээний цогцолбор. Утас: 7575-1200

- **Хороолол салбар** – Баянгол дүүргийн 13 дугаар хороо, 3 дугаар хороолол, “Соломолл” худалдааны төв. Утас: 7505-1200
- **Мишээл салбар** – Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо, “Мишээл” барилгын материалын их дэлгүүр. Утас: 7585-1200
- **Драгон салбар** – Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хороо, “Драгон” худалдаа, үйлчилгээний цогцолбор. Утас: 7577-1200
- **Оргил салбар** – Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хороо, 6 буудалд байрлах “Оргил” худалдаа, үйлчилгээний төв. Утас: 7585-1300
- **Баянхошуу салбар** – Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хороо, “Бизнес инкубатор төв”. Утас: 7510-1200

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМ МАШИН

Нийслэлийн оршин суугч өөрт хамгийн ойр байрлах төрийн үйлчилгээний ТҮЦ машинаар дамжуулан төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах, яам, агентлаг, төрийн байгууллагуудад санал хүсэлт, өргөдөл гомдлоо илгээх боломжтой.

Төрийн үйлчилгээний ТҮЦ машинаас үйлчилгээ авахад иргэний цахим үнэмлэхээ ашиглана.



- Иргэний лавлагаа
- Боловсролын лавлагаа
- Гэрлэлтийн лавлагаа
- Тээврийн хэрэгсэл
- Үл хөдлөх хөрөнгө
- Жолоодох эрхийн лавлагаа
- Хуулийн этгээдийн лавлагаа
- Нийгмийн даатгалын лавлагаа
- Цахилгааны төлбөр төлөх
- Шүүхийн шийдвэрийн лавлагаа

Дэлгэрэнгүй мэдээллийг <https://tutsmashin.gov.mn> цахим хуудаснаас авна уу.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Таны бие өвдсөн бол иргэний үнэмлэхийн хаягийн дагуу харьяа өрхийн эрүүл мэндийн төвд хандана.

Хэрэв биеийн байдал тань хүндэвтэр, мэс заслын үйлчилгээ шаардлагатай байж болзошгүй тохиолдолд заавал Өрхийн эрүүл мэндийн төвд хандалгүй шууд харьяа Дүүргийн эрүүл мэндийн төвд очиж эмнэлгийн тусламж авах эрхтэй.

ӨРХИЙН ЭМНЭЛЭГ

Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах үйл ажиллагааг үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ хамаарна.



ЭМНЭЛГИЙН МЭРГЭШСЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Тусгай зөвшөөрөл бүхий өмчийн бүх хэлбэрийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг, амаржих газар, клиник үзүүлнэ.

Нийслэлийн оршин суугчдад үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй мэдээллийг дараах эмнэлэг, байгууллагуудаас авна.

Эрүүл мэндийн даатгал

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний утас: 1800-1363

Улсын нэгдүгээр төв эмнэлэг

- Цаг товлох лавлагаа бүртгэлийн утас: 311544
- Санал хүсэлт авах утас чанарын алба утас: 326964

Улсын хоёрдугаар эмнэлэг

- Цаг товлох үйлчилгээний утасны дугаар: 7015-0222, 7015-0255
- Санал хүсэлт авах утас: 70150206
- Түргэн тусламжийн утас: 70150234
- Цахим хаяг: <http://ssch.gov.mn>

Улсын гуравдугаар төв эмнэлэг

- Цаг товлох лавлагаа бүртгэлийн утас: 70184049
- Мэдээлэл, санал, хүсэлт авах утас: 70046666

Хавдар судлалын үндэсний төв

- Цаг товлох үйлчилгээ авах утас: 70162529, 451113
- Чанар дотоод хяналтын албаны утас: 70150437
- Цахим бүртгэлийн утас: 7997-4000
- Шуурхай мэдээлэл 24 цаг: 88877539
- Цахим хаяг: <https://ecancer.mn>
- Эмнэлгийн нэр, байршил, дэлгэрэнгүй мэдээллийг www.emd.gov.mn цахим хуудаснаас авна уу.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлсөн иргэд эрүүл мэндийн даатгалын байгууллагуудтай гэрээ бүхий төрийн өмчийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад эмчлүүлэхдээ Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтийг эдэлнэ.

Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлт эдлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

- Амбулаторийн үзлэг, хяналт
- Оношилгоо, эмчилгээ үйлчилгээ
- Хорт хавдрын болон бусад хөнгөвчлөх тусламж үйлчилгээ
- Уламжлалт эмчилгээ
- Сэргээн засах болон сувиллын тусламж үйлчилгээ
- Эмчийн бичсэн жороор өгөх эмийн хөнгөлөлт
- Хорт хавдрын химийн эмчилгээ

Иргэн таны жилд нэг удаагийн амбулаторийн эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээг ЭМД-ын сангаас хариуцдаг.

- Эрүүл мэндийн даатгалын талаарх мэдээллийг <http://www.emd.gov.mn> цахим хуудас болон үйлчилгээний лавлах 1800-1363 дугаараас асууж болно.

ЭМНЭЛГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ

Иргэн та яаралтай тусламж, үйлчилгээ шаардагдсан үед

- Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 103 дугаарт дуудлага өгнө. Дуудлагаар ирсэн эмч нь анхан шатны үзлэгийг хийж, цаашид лавлагаа шатанд хүргэх эсэх эсвэл гэрээр эмчлэх эсэхийг шийдвэрлэнэ.
- Яаралтай лавлагаа, тусламж, үйлчилгээ шаардлагатай бол дүүргийн нэгдсэн эмгийн хүлээн авах, яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлнэ.
- Мэс заслын яаралтай тусламж, үйлчилгээ авах тохиолдолд ЭМС-ын 2019 оны 588 дугаар тушаалын дагуу харьяа эмнэлэгт хандана.


Хүүхэд, нярайн амь тэнссэн үед харьяалал, шатлал харгалзахгүйгээр өөрт аль ойр эмнэлгийн байгууллагад хандана.

ЭМИЙН САН

Эмийн сангаас эм, эмийн бүтээгдэхүүн худалдан авахдаа эрүүл мэндийн намтар дэвтэр болон эмчийн жороор эм худалдан авах.



Эмийн сангаар үйлчлүүлэхдээ эмчийн жороор үйлчүүлээрэй.
Та эрүүл мэндийн даатгалаар эмийн сангаас хөнгөлөлттэй эм авах боломжтой.





БАНК, САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Ихэнх банкны цагийн хуваарь даваагаас баасан гаригуудад 09:00-18:00 цагийн хооронд ажилладаг. Зарим банкны цагийн хуваарь нь ажлын өдөр болон амралтын өдөр харилцан адилгүй байдаг тул тухайн харилцагч банкны цагийн хуваарийн мэдээллийг цахим хуудас болон лавлахаас тодруулан үйлчлүүлээрэй.

Аль ч банканд биеийн байцаалттай /иргэний үнэмлэх, гадаад паспорт гэх мэт/ өөрийн биеэр очин данс, карт нээлгэх боломжтой.

АТМ

АТМ буюу бэлэн мөнгөний автомат машин ашиглан бэлэн мөнгөний орлого, зарлага, дансны дугаар болон утасны дугаараар шилжүүлэг хийх, дансны үлдэгдэл харах, картын пин код солих зэрэг үйлчилгээнүүдийг авах боломжтой. Та аль ч банкны АТМ-ээс бэлэн мөнгөний зарлага гарган авч болох ба гүйлгээний шимтгэл нь тухайн харилцах банкнаас хамааран харилцан адилгүй байдаг.



АТМ-ээр үйлчлүүлэхдээ хотын оршин суугч та дараах зүйлсийг анхаарна уу.

- Аль болох банкны дэргэд, хажууд байрлах албан ёсны цэгүүдээр үйлчлүүлэх;
- Үйлчлүүлэгч хоорондыг зайг барих. Хэрэв арын үйлчлүүлэгч хэт ойр зогсох, тухгүй байдлыг үүсгэж байвал шаардлага тавих эсвэл өөр байршлын АТМ-ээр үйлчлүүлэх;
- Картын нууц дугаараа /пин код/ алдахаас сэргийлэх. Хэрэв картаа алдсан тохиолдолд яаралтай харилцах банктайгаа холбогдон мэдээлэх;
- Пин кодоо 3 удаа буруу оруулбал таны картыг хураах болохыг анхаарна уу;
- АТМ-д картаа хийгээд 30 секунд ямар нэгэн үйлдэл хийхгүй бол таны картыг хураах болохыг анхаарна уу;
- Их хэмжээний бэлэн мөнгө авахдаа сэрэмжтэй байх, аль болох ганцаараа явахгүй байх;
- Хэтэвчээ арын халаасанд бус урд халаасандаа хийх;

- Бэлэн мөнгөө бүгдийг нэг дор бус салгаж байршуулах /урд халаас, цүнх, хүрмийн дотор халаас гэх мэт/;
- АТМ-ээр заавал үйлчлүүлэх шаардлагагүй үйлчилгээг /дансны мэдээлэл, үлдэгдэл шалгах гэх мэт/ интернэт банк болон бусад эх үүсвэрээс авах.

ИНТЕРНЭТ БАНК



Банкны боломжит бүх үйлчилгээг онлайнар буюу зайнаас интернэт банкны үйлчилгээгээр компьютер, таблет, цахим болон ухаалаг утсанд зориулсан аппликэйшнээр дамжуулан долоо хоногийн 24 цагийн туршид үйлчилгээ авах боломжтой юм.

Интернэт банк нь дансаа шалгах, гүйлгээг хянах, хуулга харах, гадаад, дотоод шилжүүлэг, гүйлгээ хийх, данс нээх, төлбөр хийх зэрэг олон боломжийг олгодог. Интернэт банкны үйлчилгээг тухайн харилцах банканд очин нээлгүүлнэ.

Интернэт банк ашиглан үүрэн телефон болон бүх төрлийн хэрэглээний төлбөрийг төлөх боломжтой.



ХУДАЛДАА, ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Улаанбаатар хотод бүх төрлийн үндэсний /япон, солонгос, хятад, мексик, энэтхэг гэх мэт/ хоол, олон улсын сүлжээ ресторанууд үйл ажиллагаа явуулдаг. Хоол захиалгыг утсаар болон социал сувгаар хийх боломжтой бөгөөд хүргэлтийн үйлчилгээг үзүүлдэг.



Ажлын цагийн хувьд томоохон зах худалдааны төвүүд нь 7 хоногийн нэг өдөр амардаг бол бусад үзвэр үйлчилгээ, ресторан, зочид буудал, сүлжээ их дэлгүүрүүд өдөр бүр тогтсон цагийн хуваарийн дагуу ажилладаг.

Нийслэл хотод бүх төрлийн худалдаа үйлчилгээний байгууллагуудаас худалдан авалт хийсэн баримтаа бүртгүүлснээр НӨАТ-ын 2 хувийн буцаан авалт буюу татварын хөнгөлөлт эдлэх боломжтой.

Худалдаа, үйлчилгээний газраар үйлчлүүлэхдээ дараах зүйлсийг анхаарна уу.

- Зөвшөөрөгдсөн авто зогсоолд тээврийг хэрэгслийг байршуулах
- Төлбөртэй зогсоолд тээврийн хэрэгслийг байрлуулсан бол тарифын дагуу төлбөр төлөх
- Төлбөргүй зогсоолд тээврийн хэрэгслээ байрлуулахдаа бусдын хөдөлгөөнд саад учруулахгүй байршуулах, утасны дугаарыг заавал үлдээх
- Нийтийн зам талбайгаар явахдаа баруун гарын дүрмийг баримтлах
- Давхар хоорондын шат, урсгал шатаар явахдаа баруун гарын дүрмийг баримтлах
- Цахилгаан шат буюу лифтээр зорчихдоо бууж байгаа иргэд бүгд буусны дараа суух
- Зөвхөн өөрийн очих давхарт очих лифтээр үйлчлүүлэх
- Худалдаа үйлчилгээний төвөөр үйлчлүүлэхдээ аюулгүй байдлаа хангахдаа

аваарын гарц, гадагш гарах гарцыг ажиглан судлах

- Аливаа гамшиг ослоос өөрийгөө болон бусдыг хамгаалах анхан шатны мэдэгдэхүүнтэй байх /галын, газар хөдлөлтийн, угаарын г.м/
- Яаралтай зорих үйлдэл үзүүлж байгаа иргэнд зам тавих
- Та дугуйгаар зорчиж байгаа бол зориулалтын зогсоолд тавьж аюулгүй байдлыг хангах
- Аливаа үйлчилгээг авахдаа зөвхөн дарааллаар үйлчлэх зарчмаар үйлчлүүлэх
- Жирэмсэн, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, бага насны хүүхдэд хүндэтгэлтэй хандах
- Олон нийтийн газар соёлтой зөв боловсон үйлчлүүлэх
- Нийтийн 00-ийг ашиглахдаа зөв боловсон, цэвэр нямбай байдлыг эрхэмлэн заасан санамжийн дагуу хэрэглэх
- Үйлчилгээний ажилтны шаардлага, санал зөвлөмжийн дагуу үйлчилгээ авах.

ТАТВАР

Албан татвар гэж хууль тогтоомжийн дагуу аливаа этгээдийн орлого, хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ.

И-баримт



Иргэн та худалдан авсан бараа, бүтээгдэхүүний төлбөрийн баримтыг www.ebarimt.mn аппликэйшны QR кодыг уншуулснаар НӨАТ-ын 2 хувийг буцаан олголтыг авах боломжтой.

Иргэд, татвар төлөгчид НӨАТ-ын урамшууллын систем, и-баримтын талаар 1800-1288 дугаарт холбогдож, татварын улсын байцаагчаас зөвлөгөө, мэдээлэл авч болно.

Цахим татвар



Цахим татварын систем болох www.etax.mta.mn нь татварын тайланг санхүүгийн программаас шууд илгээх, цахим төлбөрийн баримтын системийн өгөгдлөөс хялбаршуулсан тайланг бэлтгэдэг, цахим гарын үсгийг ашиглах зэрэг давуу талтай юм.



09 АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАНГАХ САНАМЖ МЭДЭЭЛЭЛ

- Яаралтай тусламжийн төвүүдийн мэдээлэл
- Хуулийн зөвлөн туслах үйлчилгээний талаарх мэдээлэл





ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН УТАС

Хэрэв танд түргэн тусламж хэрэгтэй үед эсвэл гал түймэр, осол аваар, хулгай дээрэм болон бусад гэмт хэрэг зэрэг онцгой нөхцөл байдалд орвол тайван байж, тусламж дуудах нь зүйтэй. Яаралтай тусламжийн тусгай дугаарууд 24 цагийн туршид үнэ төлбөргүй, хөдөлгөөнт болон суурин утаснаас шууд залгах боломжтой.

Яаралтай тусламжийн дугаарууд

 <p>Гал түймэр</p> <p>Утас: 101</p>  <p>Гал түймэртэй тэмцэр газар</p>	 <p>Гэмт хэрэг зөрчил, зам тээврийн осол</p> <p>Утас: 102</p>  <p>Цагдаагийн газар</p>
 <p>Эмнэлэгийн түргэн тусламж</p> <p>Утас: 103</p>  <p>Нийслэлийн яаралтай түргэн тусламжийн төв</p>	<p>Хүүхдийн тусламж</p>  <p>108 free Утас: 108</p>  <p>Хүүхэд хамгаалал</p>



ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА

Таны хуульд заасан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн тохиолдолд холбогдох төрийн байгууллагад хандаж, эрхээ хамгаалуулж болно. Үүнээс гадна танд хууль зүйн туслалцаа хэрэгтэй бол дараах замыг ашиглах боломжтой. Үүнд:

- Өмгөөлөгч, өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдэд хандах. Монголын Өмгөөлөгчдийн холбооны өмгөөлөгчдийн нэгдсэн бүртгэлээс сонгож үйлчлүүлэх.

Цахим хуудас: www.ama.org.mn, Утас: 70124791, 70126862

- Эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтны хувьд Хууль зүйн туслалцааны төвд хандаж улсын өмгөөлөгч авч болно. Энэ тохиолдолд дараах журмаар хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, туслалцаа авна:

- Төлбөрийн чадваргүй болохыг тодорхойлсон тодорхойлолт гаргах
- Хууль зүйн туслалцаа хүссэн өргөдөл гаргах
- Иргэний үнэмлэхийн хуулбар болон бусад баримт бичгийг бүрдүүлж, өөрийн оршин суугаа газрын болон хэргийн харьяаллын дагуу Хууль зүйн туслалцааны төвийн салбарт хандана. Хууль зүйн туслалцааны төвийн утас: 7000-1982

Сар бүрийн 3 дахь долоо хоногийн Лхагва гарагт Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд иргэдэд хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх өдөрлөгийг зохион байгуулдаг.

Хүний эрх хөгжил төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо зэрэг төрийн бус байгууллагууд, МУИС-Хууль зүйн их сургуулийн дэргэдэх хууль зүйн зөвлөгөө өгөх практик сургалтын төвөөс үнэ төлбөргүй тухайн чиглэлээр суралцаж буй оюутан суралцагчид иргэдэд үнэ төлбөргүй эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг.



ХУВИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ:

Иргэд өөрийн хувийн болон бусад аюулгүй байдлыг хэрхэн хангах, хамгаалах талаар дараах зүйлсийг анхаарна уу!

Хувийн аюулгүй байдалдаа анхаарах зүйлс:



Аль болох ганцаараа явахгүй байх, хөл хөдөлгөөнтэй, гэрэлтэй эсвэл машин зам дагуу явах,




Такси барих бол албан ёсны такси компаниар үйлчлүүлэх



Авто замын хөдөлгөөнд оролцох үед гар утас хэрэглэхгүй байх;



Авто замын хөдөлгөөнд бага насны хүүхдийг хараа хяналтгүй ганцааранг нь оролцуулахгүй байх;



Замын хөдөлгөөнд оролцохдоо зөвхөн зөвшөөрөгдсөн цэгээр гэрэл дохио, цагдаагийн дохиогоордүрмийн дагуу оролцож аюулгүй байдлыг хангах



Хөдөлгөөнд оролцохдоо чихэвч хэт чангалан хэрэглэхгүй байх;



Биеийн байцаалт бичиг баримтыг биедээ авч явах;



Явган замын саравчны бүрэн бүтэн байдлыг харгалзан зорчих;



Олон нийтийн газар хувийн эд зүйлсээ алдахаас сэргийлэн анхаарал болгоомжтой байх;

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол улсын хууль, эрх зүйн баримт бичиг:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль
3. Нийслэлийн эрхзүйн байдлын тухай хууль
4. Хот байгуулалтын тухай хууль
5. Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль
6. Бусад байгаль орчин, хот байгуулалт, барилга нийтийн аж ахуйн салбарт хамаарах хууль, журам, дүрэм.

Бодлогын баримт бичиг, хөтөлбөр:

1. Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого /Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоол/
2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
3. Бусад байгаль орчин, хот байгуулалт, барилга нийтийн аж ахуйн салбарт хамаарах хөтөлбөр, журам, дүрэм
4. “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр
5. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлага
6. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр
7. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020- 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
8. Улаанбаатар хотод шилжин ирэгсдэд зориулсан гарын авлага-2020

Гадаад материал:

1. Guide to living in Korea 2019
2. Guide to living in Melbourne – Australia
3. Guide to living Japan

Цахим хуудас:

1. <https://www.ubtz.mn/>
2. <http://www.e-khutuch.mn/>



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж -7/1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011



7011-8060



www.standart.ub.gov.mn



Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт,
зохицуулалтын газар